

ГЕРМАН УЛСТАЙ ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН
САЛБАРТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТАЛААР
БНМАУ-ААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГАА (1925-1926)

Р. Төрдалай

Монгол Улсын Их Сургууль, Монгол судлалын төв.

Өгүүллийн товч утга: Монгол Улсын гадаад харилцааны болон улс төрийн түүхийн судалгаанд Монгол-Германы 1920-30-иад оны үеийн албан бус түүхэн харилцааг тусгайлсан зүйл өнөө хэр ховор байна. Гэтэл XX зууны эхэн хагас дахь Монгол-Германы албан бус харилцаанд холбогдох урьд өмнө судлагдаагүй түүхэн баримтуудыг судалгааны эргэлтэнд оруулах, цаашид энэ чиглэлд судлаачдын сонирхолыг хандуулах, манай түүх бичлэгт эхлэлийн төдий явагдаж байгаа эл асуудлыг өргөн цар хүрээнд судлах заильшгүй шаардлага бидний өмнө тулгарч байна. Иймээс уг өгүүлэлдээ Монгол-Германы хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох асуудлаар явагдсан анхны уулзалт, хэлэлцээр (1925-1926)-үүдийн тухай, ялангуяа тухайн үеийн БНМАУ-ын зүгээс энэ талаар хэрээн анхаарч ажиллаж байсан зэрэг асуудлуудыг магистрын судалгааны ажилдаа тулгуурлан бага боловч тодруулахыг оролдсон болно.

Түлхүүр үг: БНМАУ-ын тусгаар тогтнол, олон түшигт гадаад бодлого, үндэсний эрх ашиг, олон улсын харилцааны хандлага, Монгол-Германы худалдаа, эдийн засгийн харилцаа

1921-1930-иад он бол манай улсын XX зууны түүхийн сонирхол татсан зурvas үе юм. Энэ цөөн хэдхэн жилийн хугацаанд Монгол Улс (1924 оноос БНМАУ) нийгэм, эдийн засаг, соёлын салбарт харьцангуй бие даасан, олон түшигт гадаад харилцааг идэвхтэй явуулахыг чармайж, чамгүй үр дүн, амжилтад хүрч байжээ. Үзэл суртлын тэмцэл, нийгмийн тогтолцооны ялгааг үл харгалзан Герман, Франц, Дани, Щвейцарь, Их Британи, АНУ, Унгар, Польш, Итали зэрэг олон орнуудтай ямар нэг хэмжээгээр холбоо харилцаатай байсны дээр Герман Улстай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг энд онцгойлон үзэхээс өөр аргагүй юм.

Өдгөө судлаачид Монгол-Германы дурьдан буй үеийн харилцааг судлах талаар анхаарч байгаа ч хоёр улсын хооронд харилцаа тогтоох талаархи анхны хүчин чармайлтууд, ялангуяа БНМАУ-аас энэ талаар явуулсан үйл ажиллагааг судалсан зүйл ховор байна. Иймээс энэхүү өгүүлэлдээ XX зууны эхэн хагаст БНМАУ-аас худалдаа, эдийн засгийн салбарт Герман Улстай харилцаа тогтоон хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хөнден авч үзэхийг оролдсон билээ.

Юуны өмнө, Монгол-Германы хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох асуудал нь хоёр талын харилцан ашиг сонирхлоос улбаатай болохыг онцлог тэмдэглээ. Анх 1922 онд Москва дахь Германы элчин сайдын яамны зөвлөх, Бээжин дэх Германы элчин сайдын яамны худалдааны атташе, Дорнод Европыг судлах Германы нийгэмлэгийн нарийн бичгийн дарга нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Нийслэл Хүрээнд хүрэлцэн ирсэн бөгөөд уг үйл явдлыг тухайн үед "Власть труда" сонини 1922 оны VIII сарын 19-ний дугаарт нийтэлж байжээ.¹

Академич Ж. Болдбаатар БундесАрхивт буй эх сурвалжид үндэслэн тэдгээр төлөөлөгчдийг Германы дипломатч Херманн Гипперах, доктор Армис нар болохыг тогтоосон билээ².

¹ Үндэсний Төв Архив, Фонд 382. данс. 3. хадгаламжийн нэгж – 51.

² Болдбаатар. Ж. Түүх зулсан он жилүүдийн ойллого, боть I, Улаанбаатар 2003, ХБНГУ-ын БундесАрхивт буй Монголын тухай баримт сэлт (1921-1930), 290-р тал.

Тэдгээр төлөөлөгчид Монголд байх хугацаандаа худалдаа, эдийн засгийн зарим хэлэлцээр хийж, манай улсад өөрийн хөрөнгө оруулалтаар Төмрийн завод байгуулах сонирхолтой байгаа тухайгаа Засгийн газарт албан ёсоор мэдэгдэж байжээ. Гэвч эдгээр төлөөлөгчид нь Монгол Улсад болж байсан улс төрийн үйл явцыг тандан судлах, Монголын талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах зорилготой байсан бололтой. Энэ тухай ноён Гиппериш 1922 оны VII сарын 25-нд Бээжин дэхь Элчин сайдад бичихдээ “Монголын албан газрууд Германд ихээхэн найрсаг хандаж байх шиг байна. Ерөнхий сайд надаас ямар зорилго, төлөвлөгөөтэй ирснийг асуугаад, бух талын дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна гэв. Герман хүний нь хувьд намайг Монголын эгэл жирийн хүмүүс ч маш элэгсэг дотно хүлээн авч байна³” гэж тэмдэглэжээ. 1922 оны VIII сарын 5-ны өдөр доктор Армис Ерөнхий сайд болон Гадаад Явдлын, Цэргийн яамны сайдуудад бараалхсан ба түүний бичсэнээр уулзалт хэлэлцээр гурван цаг гаруй үргэлжилж, манай талаас Герман Улсын тусламжтайгаар аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, Германы лүүсүүдийн тоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг доктор Армисаас дахин дахин хүсч байжээ⁴.

Уг айлчлалын үр дүнд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох талаар ийнхүү зарим нэг тодорхой тохиролцоонд хүрсэн чухал уулзалтууд Монгол-Германы албаны хүмүүсийн хооронд болж өнгөрсөн бололтой. Манай Улсын удирдах албаныхан техник, технологи өндөр хөгжсөн Герман Улстай худалдаа, эдийн засгийн өргөн дэлгэр харилцаа тогтоох асуудлыг ихээхэн сонирхож байсан нь эргэлзээгүй юм. Германы дипломатч Херманн Гиппериш, доктор Армис нарын хагас албан ёсны шинжтэй энэ айлчлалын үеэр манай тал Герман Улстай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох, нөхцөл байдлыг судлах зорилгоор худалдааны төлөөлөгчдөө илгээхээр шийдсэнээ албан ёсоор мэдэгдсэн байна. Энэ тухай доктор Армис бичихдээ "... Урьдах өдөр бас цэргийн яамны сайд энэ тухай надад ярьж байсан. Энэ асуудлыг зарчмын хувьд аль хэдийн шийдвэрлэсэн боловч төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд хэн хэнийг оруулах, хэдийд явуулах талаар одоо болтол тодруулан өгсөн зүйл хараахан үгүй байна... Хожим би өөр нэг сурвалжаас Ерөнхий сайд, буриад Ринчино нарыг явуулахаар тогтсон гэж сонсов⁵” гэсэн байдаг.

Мөн зарим түүхэн баримтаас үзвэл Хаалган хот дахь АНУ-ын Консулын газар, Оросын Чита хот дахь Германы Консулын газрууд Монгол Улстай албан бус харилцаатай байсан баримт мэдээ байдаг. Энэ тухайд холбогдох нэгэн сонирхолтой баримт нь Хаалганд сууж байсан АНУ-ын консул Самуэл Сокобин 1922 оны VIII сарын 16-нд Төрийн нарийн бичгийн даргадаа бичсэн тайлан юм. Самуэл Сокобин бичихдээ "... Читад суугаа Германы консулын газрынхан Хүрээнд үргэлж ирж очиж, тэд Монголчуудтай хэл амаа ололцон ойртож байна. Энэ нь Германчууд Монголыг Хятадад хамаагүй тусгаар тогтносон улс хэмээн үздэгтэй холбоотой хэрэг байх⁶” гэж дүгнэсэн нь ихээхэн сонирхол татах байгаа юм.

1923 оны III сарын 21-нд Монгол Улсын элчин сайд Жадамбаа Москвад суугаа Герман Улсын Элчин сайдын яамны зөвлөх доктор Армисийг хүлээн авч уулзах үеэрээ Герман Улстай бүх талын харилцаа тогтоохыг онцгойлон дэмжихээ илэрхийлээд Герман Улс Монгол Улсад бие даасан улсын ёсоор хандах ёстойг тэмдэглэж байжээ⁷ гэж мэдэгдэж байжээ. Мөн 1923 оны IX сард Дундад Улсад суугаа Герман Улсын элчин сайдын зөвлөх Кибор Нийслэл Хүрээнд албаны хэргээр хүрэлцэн ирсэн тухай баримт байна. Тэрээр хоёр улсын

³ Мөн тэнд

⁴ Мөн тэнд

⁵ Мөн тэнд

⁶ БНМАУ-ын Гадаад харилцааны түүхчилсэн товч лавлах, Улаанбаатар, ГЯЯ, ШУА, ГЯЯ-ны Архив, 1987, 162-р тал.

⁷ Болдбаатар. Ж, дурьдсан зохиолд.

хооронд албаны ямар нэгэн гэрээ, хэлэлцээр хийсэн тухайд маш бүрхэг байгаа ч манай талаас түүний зорьж ирсэн үйл хэрэгт зохих дэмжлэгийг үзүүлсэн байна. Энэ тухай Монгол Улсын Гадаад Явдлын яамны 1923 оны IX сарын 20-ны өдрийн № 852 тоот албан бичигт дурьдсан байна⁸.

Дээрээс харахад 1925 он хүртэлх хугацаанд Монгол-Герман улсууд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох боломжийн талаар харилцан судалж зохих албаны хүмүүсийг томилон явуулж байжээ. Дурьдан буй үед Монгол Улс дахь гадаадын эдийн засаг, худалдааны ашиг сонирхлыг дэмжих таатай орчинг бүрдүүлэхэд ихэд анхаарч байсны үр дүнд 1923 оны байдлаар Монгол Улс дахь Англи, Америк, Германы пүүс 26 байсан бол 1924 онд 62 болж тоо нь өссөөр байжээ⁹. Хэдийгээр энэ үед ЗХУ болон Коминтерноос манай улсын дотоод, гадаад бодлогыг чиглүүлэн удирдах байдал хүчтэй болсоор байсан ч МАХН-ын Төв Хороо, Ардын Засгийн газраас Герман Улстай харилцах асуудлыг чухалчлан үзэж байв. 1924 оны XI сарын 3-ны өдөр Монгол Улсаас ЗХУ-д суух бүрэн эрхт элчин сайдаар томилогдсон А.(Япон)Данзанд Монгол Улсын Ерөнхий сайд Б. Цэрэндорж Москвад суугаа гадаад орууудын элчин сайдууд тэр дундаа тусгайлан Германы элчин сайдтай биөчлэн уулзаж, Герман Улсын улс төрийн байдал, Монгол Улсын талаар баримталж байгаа бодлого, чиглэлийн нь тухай мэдээлэл авах, Германы монгол судлаач эрдэмтэдтэй холбоо тогтоох, зохиол бүтээлүүдээс нь ирүүлэх зэрэг ажлын удирдамж чиглэл өгсөн байна¹⁰.

Элчин сайд А.(Япон)Данзан үүрэгт ажилдаа орсон өдрөөс эхлэн Засгийн газраас өгсөн дээрх чиглэлийн дагуу ЗХУ-тай харилцаагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Москва хот дахь Герман, Франц, Япон, Хятад зэрэг гадаад улсуудын элчин сайд, дипломат төлөөлөгчидтэй биеэр очиж уулзан эдгээр улсуудтай найрсаг харилцаа тогтоож, Монгол Улсын тусгаар тогтолыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэх, худалдаа, эдийн засаг, соёлын харилцаа тогтоох асуудлыг хөндөн ярилцаж байжээ. Элчин сайд А.(Япон)Данзаны Герман Улстай харилцаа тогтоох идэвхтэй оролдлого талаар өнгөрөөгүй бөгөөд 1925 оноос манай хоёр улсын харилцан хүчин чармайлтын үр дүнд худалдаа, эдийн засаг, соёл боловсролын салбар дахь харилцаа холбоо эрс идэвжсэн байна.

Мөн энд зайлшгүй тэмдэглэх ёстой нэг асуудал бол Монгол-Герман хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа тогтооход чиглэгдсэн анхны үйл ажиллагаа зохих амжилт олоход Москва дахь Германы элчин сайд фон Брокдорф-Ранцау (*von Brockdorff-Rantzau*) гүнгийн санаачилга, оролцоо зохих нөлөө үзүүлснийг дурьдах хэрэгтэй болов уу? Москва дахь Герман Улсын элчин сайдар сууж байсан фон Брокдорф-Ранцау (*von Brockdorff-Rantzau*) бол Герман Улсын улс төрийн байр суурийг ЗХУ-тай харилцан найрамдалт харилцааг хөгжүүлэх чиглэлийг баримтлаж байсан Герман Улсын улс төрчдийн нэг байв. Иймээс Монгол-Германы харилцаа өргөжин бэхжихэд ЗХУ-ын талаар аядуу байр суурийг баримтлаж байсан Герман Улсын зарим улс төрчдийн байр суурь чухал үүрэг гүйцэтгэж байсныг үгүйсгэх аргагүй юм. 1925 оны гармагц Герман Улсад худалдааны төлөөлөгч нарын бүрэлдэхүүнийг илгээх тухай асуудал үндсэндээ шийдэгдсэн байна.

1925 оны IV сард БНМАУ-ын Засгийн газрын ажилтан Даш Сампилон, инженер В. Хурлат нарыг худалдааны төлөөлөгчдөөр сонгон Герман Улсад явуулжээ. Герман Улсад худалдааны төлөөлөгчөөр сонгогдсон инженер Хурлатын тухай материал архивт хадгалагдан үлдсэн байна.

БНМАУ-ын Гадаад Явдлын яамны 1925 оны IV сарын 7-ны өдрийн № 360 тоот албан бичигт Герман Улсад үйлдвэрийн багаж хэрэгсэл худалдан авах,

⁸ Монгол улсын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс - 1, нугалбар № 1

⁹ Идшинноров. С. Хот суурины хувийн хэвшлийн хөгжил, хувьслын асуудалд /1921-1960/, Түүхийн ШУ-ны дэд доктор /Ph.D-ын зэрэг горилсон бутээл, Улаанбаатар, 1993, 17-р тал

¹⁰ Монгол Улсын Гадаад Хэргийн яамны Төв Архив. Фонд 01ш. Хадгапамжийн нэгж – 1173

судлах ажлаар томилогдсон Аж ахуйн яамны инженер Хурлатыг хилээр саатуулахгүй нэвтрүүлэхийг ЗХУ, Германы гаалийн албаны удирдлага, ажилтнуудаас албан ёсоор хүссэн байна¹¹. Герман Улсад явах худалдааны төлөөлөгч Даш Самиллон, В. Хурлат нарт Засгийн газраас Берлин хотод Монголын худалдаа, соёлын төлөөлөгчийн газрыг нээх, БНМАУ-д ажиллах төрөл бүрийн салбарын мэргэжилтэн, сургагч нарыг олж ирүүлэх, зарим үйлдвэрийн газруудыг шинээр барьж байгуулах, төхөөрөмжлөх талаар Герман Улсын холбогдох газруудтай холбоо тогтоож, дэмжлэг авч болох эсэх талаар судлах, Монгол орны ашигт малтмал, тэдгээрийн орд газрыг нээн илрүүлэх, зураглал зохиох, лабораторын шинжилгээ хийх асуудлаар дэмжлэг авах, БНМАУ-д нэн шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмж, бараа таваарыг байнга нийлүүлэх томоохон пүүс, фермүүдтэй холбоо тогтоох, БНМАУ-аас Герман Улсад түүхий эд экспортлох тухай асуудлаар албан ёсны гэрээ, хэлэлцээр хийх, Герман, Францад оюутан суралцуулах асуудлыг судлах гэх мэт маш олон үүрэг даалгавар өгсөн байна.

Энэ айлчлалын үр дүнд Монгол-Герман хооронд худалдаа, эдийн засаг болон соёл боловсролын харилцаа тогтоох талаар үндсэн тохиролцоонд хүрч чадсан байна. БНМАУ-ын худалдааны төлөөлөгчид Герман Улсад очсон тухай он цагийн нарийн мэдээ баримт тун бүрхэг байгаа боловч архивийн баримт мэдээ бусад холбогдох эх сурвалжуудаас авч үзвэл 1925 оны V сарын эхээр хүрэлцэн очсон болов уу гэх үндэслэл байна. Энэ тухай Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргааны дарга Б. Ишдоржийн зөвлөхөөр ажиллаж байсан С. М. Вольф* хожим 1964 оны хавар Лондон хотноо Хааны Төв Азийн сэргүүлд бичсэн "Баруун Европ дахь Монголын боловсролын зоримог үйл хэрэг" хэмээх дурсамж өгүүлэлдээ 1925 оны V сарын эхээр Берлинд байгуулагдсан Монголын Худалдааны төлөөлөгчийн газрын удирдлагуудтай уулзсан тухайгаа тодорхой бичсэн байдаг¹². Мөн манай ГХЯ-ны Төв Архивт хадгалагдаж байгаа Монгол-Германы харилцааны холбогдолтой баримтуудад Самиллон, Хурлат нар Герман Улсаас худалдан авсан машин, техник, бараа таваарын зүйлсээ Орос-Германы хамтарсан тээврийн пүүсээр дамжуулан БНМАУ-д явуулсны хөлс (Тэд дойч марк, америк доллар, англий фунт зэрэг валютар тооцоо хийсэн ажээ. Р. Т) зэргийг нэхэмжлэсэн хуудас Аж ахуйн яаманд ирсэн байна¹³.

Энд онцлон тэмдэглэхэд, худалдааны төлөөлөгчид дээрээс өгсөн чиглэл, даалгаврыг өндөр түвшинд гүйцэтгэж байжээ. Даш Самиллон, В. Хурлат нар Герман Улсын Берлин, Гамбург, Дрезден зэрэг хотуудаар явж, БНМАУ-д гэрээгээр ажиллах мэргэжилтнүүдээр нэлээд олон хүнийг элсүүлэн авч чадсан байна¹⁴. Гэрээ ёсоор БНМАУ-д урилгаар очиж ажиллах мэргэжилтэнүүдтэй гэрээ байгуулж, хоёр талын хүлээх үүргийг тодорхой зааж тохиролцжээ. Гэрээнд зааснаар БНМАУ-ын Засгийн газрын хүлээх үүрэг нь сар бүр 225-250 мексик долларын цалин олгох, орон сууцаар үнэгүй хангах, ирэх, буцах замын зардлыг

¹¹ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6 Монгол-Германы харилцааны данс – 3-1, нугалбар № 2.

* Сергей Михайлович Вольф (? - 1979) Орос гаралтай. 1908 онд Петербургээс эцэг, эхийн хамт Англид цагаачлан ирсэн бөгөөд дараа нь Кембрижийн Их Сургуульд боловсрол эзэмшиж байна. 1925-1929 онд Берлин хотод байсан "Монголын худалдаа, соёлын төлөөлөгчийн газар"-т орон тооны хэлмээр, зөвлөх, Герман Улсын ерөнхий боловсролын болон тусгай мэргэжлийн сургуулиудад суралцаж байсан монгол хөвгүүд, охидын хүмүүжүүлэгч багшвар ажиллаж байжээ. Тэрээр ийнхүү монгол запуулж туслахын эзэрцээ Берлин хот дахь Английн мэдээлэлээний клубт лекц үншиж тухайн үеийн Монгол Улсын талаар тун хөвөрт тооцоодох, унэн бодит мэдээллийн олон нийтдээ хэвлэлээр танилцуулж ажлыг хийж байв. Тэрээр Берлин дэхь Монгол Улсын Худалдааны төлөөлөгчөөр ажиллаж байсан Б. Нэмсрайтэй хамтран ажиллаж байжээ.

С. М. Вольф 1964 онд Монголд анх ирсэн бөгөөд мөн 1970 онд Олон улсын Монголч эрдэмтдийн II их хуралд оролцож хоёр дахь удаагаа ирсэн байна. 1964-1979 онд өөд болох хүртэлээ Англи-Монголын нийгэмлэгийн дэд даргаар ажиллаж байжээ. 1920-иад онд Герман, Францад суралцаж байсан монгол сурвагчдын талаар эх сурвалжийн шинжтэй хэд хэдэн өгүүлэл бичиж хэвлүүлсэн.

¹² Serge M. Wolff, Mongolian Educational Venture in Western Europe /1926-1929/, Zentralasiatische Studien 5(1971), 268-р гал.

¹³ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс – 1-1д, нугалбар № 39.

¹⁴ Идшинноров С Хот суурины хувийн хэвшилийн хөгжил, хувьслын асуудалд /1921-1960/, Түүхийн ШУ-ны дэд доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар 1993, 44-р тал.

төлж байх, эмнэлэгийн үйлчилгээгээр сайн хангах, өмч хөрөнгийг нь хамгаалах гэж заасан бол герман мэргэжилтнүүдийн хүлээх үүрэгт БНМАУ-д ажиллах хугацаандаа өөрийн хариуцсан ажиллах өмч хөрөнгө, материалд ариг гамтай хандаж, бүрэн бүтэн байдал, ажиллагааг хангах, Аж ахуйн яамнаас өгсөн үүрэг, даалгаврыг нягт нямбай гүйцэтгэх, туршлага мэдлэгээ бүрэн дайчлан ажиллах, БНМАУ-ын холбогдох хуулийг чанад мөрдөн сахих, улс төрийн аливаа ажиллагаа хийхгүй байх, гадаадын аль нэг фирм, үйлдвэр байгууллагыг төлөөлөхгүй байх зэрэг асуудлууд багтаж байлаа¹⁵.

1925 оны VII сард Даш Сампilon, В. Хурлат нар Герман Улсын ГЯЯ-ны холбогдох албан тушаалтуудтай уулзаж ярилцан Берлин хотод “Монголын худалдаа, соёлын төлөөлөгчийн газар” нээх тухай ярилцжээ. Түүнчлэн Сампilon энэ үеэр “Deutsche Allgemeine Zeitung” сонины эрхлэгч T. Стревед Монголын тухай сонирхолтой ярилцлага өгч байжээ¹⁶. Герман Улсын Засгийн газрын холбогдох албан тушаалтууд ч БНМАУ-тай худалдаа, эдийн засаг, соёл боловсролын харилцаа тогтоох асуудлыг анхааран үзэж бүх талаар дэмжихээ илэрхийлж байжээ. Тодруулбал энэ үед Германы удирдах албаны хүмүүсийн дунд Герман-Монголын хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоож их хэмжээний экспорт, импортын бараа, бутээгдэхүүн, түүхий эдийг харилцан нийлүүлэх, Герман Улсын Худалдаа дэмжих фондоос хэдэн сая маркийн хөрөнгө гаргах асуудлаар идэвхтэй яриа хэлэлцээ болж байсан тухай сонирхол татам баримт байна¹⁷.

1925 оны VII сарын 19-нд Даш Сампилоноос Москва хот дахь элчин сайдын яамаар дамжуулан Аж ахуйн яамнаа илгээсэн албан захидалдаа энэ тухай тодорхой дурьджээ. Даш Сампilon бичихдээ “...Бид нар Герман Улсын Гадаад яамны түшмэд нар лугаа учирч манай Монголын дотоод гадаадын байдал төлөвийг илтгэн тодорхойлсон дор тэд нарын хэлсэн нь Герман Улс болбоос дипломатын ба улс төрийн политикийн ёсоор Монгол Улсыг сонирхон үзэх ба түүний тухай хэлэлцээ хэлэлцоу үл чадах боловч эрдэм соёлын ёсоор Монгол ард түмний байдлыг мэдэн авч, аливаа боловсронгуй эрдмийн тусламж хургэхийг хүсэж баймой хэмээсэн...¹⁸” тухай өгүүлсэн байдаг. Энэхүү түүхэн баримт нь тухайн үеийн Герман Улсын зүгээс БНМАУ-ыг хэрхэн үзэж байсныг нотлон харуулж байна.

Сампилионы захидалд цааш дурьдсанаар Герман Улс Засгийн газрын түвшинд албан ёсны төлөөлөгчөө ирүүлж (Берлины Их сургуулийн багш, профессор R. T) Монголын байдлыг судлуулахаар шийдвэрлэсэн нь тухай бичжээ¹⁹.

Герман Улс тухайн үед БНМАУ-ын дотоод асуудалд ЗХУ-аас хутгалдан оролцох болсон зэрэгт шүүмжлэлтэй хандаж байв. Энэ үед Герман Улс Монголд өрнөж байсан асуудлуудыг анхааралтай ажиглаж байжээ. Мөн БНМАУ дахь Оросын нэлөөний хүрээг сулруулах бодлого баримтлахын тулд БНМАУ-ын удирдагчдын Герман Улсад хандсан үйл ажиллагааг аль болохуйц дэмжих бодлого барьж байсан бололтой. Гэтэл нөгөө талаар өдгөө нээлттэй болж буй хуучин ЗХУ-ын үеийн архивийн нууц баримтуудаас үзвэл 1920-иад оны дунд үед ЗХУ нь Германы капиталыг Монголд оруулахыг дэмжиж байсан баримт байх юм. 1925 оны VI сарын 11-ний ОК(б)Н-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 66-р хуралдаанаас гаргасан тогтоолд “ЗСБНХУ “Монголор” хэмээх үйлдвэр аж ахуйн ажилд оролцож чадахгүй нь харамсалтай байна гэж Монголын Засгийн газарт мэдэгдэх. Монголын Засгийн газарт Германы капиталыг татан оролцуулах

¹⁵ С. Мөн тэнд, 45-р тал.

¹⁶ Serge M. Wolff, дурьдсан өгүүлэл, 280-р тал.

¹⁷ Намжим. Т., Монголын аж ахуй, эдийн засаг (Түүхэн гурван үед), 2-р боть, Улаанбаатар 2000, 517-р тал.

¹⁸ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс – 1-1д, нугалбар № 40.

¹⁹ Мөн тэнд.

санал тавьж, тийнхүү татан оролцуулахад бидний хүчин туслахад бэлэн байгааг мэдэгдэх.

Төв Хорооны нарийн бичгийн дарга И. Сталин²⁰ гэжээ.

Дээрхи баримтад түшиглэн үзвэл ЗХУ-Германы хооронд тухайн үед далдуур ойртол, нягтрал явагдаж байсан ба өдгөө энэ нь хэн бүхэнд нэгэнт ойлгомжтой болжээ. ЗХУ-Германы энэхүү далд хамтын ажиллагаа нь Монгол-Германы харилцаанд хэрхэн нөлөөлсөн эсэх нь өдгөө ч тодорхойгүй асуудал хэвээр байна. Цаашид нарийвчлан судлууштай асуудал энэ хүрээнд цөөнгүй бий. Юутай ч дурьдан буй үед Герман Улсаас манай талтай хийх худалдааг Оросын Сибирийн төмөр замаар дамжуулан явуулах тухай идэвхтэй яриа хэлэлцээ ч явагдаж байжээ. БНМАУ-ын худалдааны төлөөлөгчдийн айлчлалтай давхцан бас нэгэн “сонирхолтой аялал” болсон нь 1926 оны XI сараас 1927 оны I сарын эцэс хүртэл хугацаанд МАХН-ын Намын Төв Хороосны дарга Ц. Дамбадорж, Намын Төв Хорооны орлогч дарга Н. Жадамбаа нар Москвад сууж байсан элчин сайд А. Данзан(Япон), БНМАУ дахь Герман Улсын “Востваг” пүүсийн удирдлагуудтай тохиролцож зөвшилдөн 3 сарын хугацаатайгаар Герман, Франц, Итали орнуудаар явсан юм²¹.

Тэдний томилолт нь Судар бичгийн хүрээлэнгийн өмнөөс Өрнөд Европ дахь монгол судлал хөгжиж байгаа улсуудын их сургууль, хүрээлэнтэй холбоо тогтоох гэсэн агуулгатай байсан төдийгүй уг айлчлалын тухай мэдээ баримт тун ховор байгаа нь ЗХУ-ын удирдлагуудаас нууж айлчласантай холбоотой нь эргэлзээгүй. Томилолтын агуулгаар бол эрдэм шинжилгээ, соёлын асуудалд гол анхаарлаа хандуулах ёстой байсан ч тэдний томилолт илүү өргөн хүрээг хамарч улс төрийн агуулагатай болсон гэж үзэж болно.

Өөрөөр хэлбэл, тэдний айлчлалыг тодорхойлбол нэг талаар албан ёсны мэт боловч зарим талаар албан бус өвөрмөц бүтэцтэй болсон юм. Ц. Дамбадорж томилолтынхоо явцад Берлинд Лайпцигийн Конрадын коллежийн Зүүн Азийн салбарын эрхлэгч, профессор Э. Хэниш (1880-1966), С. М. Вольф, Герман Улсын ГЯЯ-ны Алс Дорнодын хэлтсийн ажилтнуудтай уулзаж Германаас монголч эрдэмтэн урин аваачих, монгол сурагчдыг илгээн суралцуулах зэрэг асуудлыг тавихын зэрэгцээ Герман Улстай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоон мэргэжилтнүүдийг гэрээгээр ажиллуулах тухайд албан тохиролцоог хийсэн байна²². Гэвч Ма Хо-Тайны 1926 онд Ц. Дамбадоржтой уулзсан тухайгаа бичсэн дурсамжинд түүнийг Герман, Францаар явахдаа “мөнгөөр туйлж” 30.000 ам. доллар зарцуулсан тухай²³ бичсэн байдаг ба энэ тухай хожим намын хурал дээр ч шүүмжлэл явагдаж байсан юм. Юутай ч худалдааны төлөөлөгч Сампилон, Хурлат нарын айлчлалыг давтсан шинжтэй болсон Монголын албаны хүмүүсийн Герман дахь аялал, нөгөө талаар айлчлал нь зохих үр дүнд хүрсэн нь эргэлзээгүй бөгөөд Герман Улстай худалдаа, эдийн засгийн өргөн харилцаатай тогтоох боломж улам нээлттэй болсон юм.

Мөн энэ үед дээрх үйл ажиллагааг батлагаажуулсан нэгэн шийдвэр гарсан нь Ардын Засгийн газрын даалгавраар ЗХУ-аас бусад гадаад орнуудтай найрсаг харилцаа тогтоож, хөгжүүлэх тухай заалт Москвад сууж байсан Монголын Бүрэн Эрхэт төлөөлөгчийн газрын 1926 оны дүрэм болон Гадаад явдлын яамны 1927 оны дүрэмд орсон явдал юм²⁴. Монгол-Германы дээрх уулзалт хэлэлцээрүүдийн үр дүнд Берлин хот дахь “Монголын Худалдааны Төлөөлөгчийн Газар” нь хоёр улсыг холбосон худалдаа, эдийн засгийн өргөн харилцааны илэрхийлэл болж чадсан байна.

²⁰ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1921-1932). Баримтын эмхэтгэл, боть I, Улаанбаатар 2002, 191-р тал.

²¹ Serge M. Wolff, Mongol Delegation in Western Europe, /1925-1929/. Royal Central Asian Journal, London , 1944.

²² Мөн тэнд

²³ Р. А. Рупен, ХХ зууны Монголчууд, (Хатигин Г. Акимийн орчуулга), Улаанбаатар, Мон-Судар, 2000, 248-р тал

²⁴ Монгол Улсын Гадаад Хэргийн яамны Төв Архив. Фонд 01. Хадгаламжийн нэгж – 274.

Эцэст нь онцлон тэмдэглэхэд Монгол-Герман хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа өргөжин хөгжихөд Берлин хотноо томилогдон ажиллаж байсан Монголын худалдааны төлөөлөгч Даши Сампилон, В.Хурлат нарын идэвх, оролцоо чухал үүрэг гүйцэтгэснийг онцлон тэмдэглэлтэй. Мөн Ерөнхий сайд Б.Цэрэндорж, Гадаад Явдлын яамны сайд В.Дорлигжав, Аж ахуйн яамны сайд А.Амар, МАХН-ын Төв Хорооны дарга Ц.Дамбадорж зэрэг манай улсын удирдах дээд албаныхан Герман зэрэг өrnөдийн улс, гүрнүүдтэй харилцан тэгш эрх, дотоод хэрэгт үл оролцох зарчмын үүднээс худалдаа, эдийн засаг, соёл, боловсролын салбарт өргөн хэмжээнд хамтран ажиллахыг чухалчлаж байв.

Тодруулбал улсын дайтай улс байх гэсэн Монголчуудын үндэсний эрх ашгаас улбаатай түүхэн эрмэлзлэл нь Өrnөдийн хөгжингүй улс, гүрнүүдээр шинэ тулгар БНМАУ-ын тусгаар тогтолыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлж, төрийн харилцаа тогтоосноор жинхэнэ утгаараа биөлэгдэх боломжтой байсныг тэд сайн мэдэж байсан юм.

Иймээс ЗХУ-аас гадна гадаад түншлэлийн хоёрдагч замыг сонгож, олон түшигт харилцааг төрийн бодлогынхоо үндсэн чиглэл болгож байжээ.

Abstract:

The magistrial dissertation, "*Relationship of Trade and Economy between Mongolia and Germany (1921-1938)*", deals with some issues, as regards the history of informal relationship between our two countries, which has not been investigated until now. In other words, the first section of this work includes many questions such as a prerequisite of establishment of informal relationship between Mongolia and Germany, their mutual efforts directing towards the establishment of relationship, how the fact that Mongolian students studied in Germany connects to the relationship of trade and economy between these two countries, and so forth.

In principal section of this work, I pay attention to investigate particularly the activities of German companies in Mongolia, as well as the industries, factors and constructions which had been established in Mongolia by means of German investments and personnels. In this section, I directed my attention to prove that the friendly asisstances, experts, and personnels, of German took important role in the development of Mongolian modern industry.

In final section, I give special emphasis to investigate the political or economical factories, which influenced, positively or negatively, on the development of informal relation between Mongolia and Germany, by explaining them in connection with contemporary trends and states in the regional or international relations. In particular, I try to deal with many issues such as the efforts in 1921-1938 made by People's Republic of Mongolia regarding to advance the relations of trade and economy with western countries, for example Germany.

In summary, Mongolia conducted geniune activities in rank like other countries in the beginning of 1920s. During this time, it adopted independent foreign policies and related friendly to Germany in spite of the difference of their social structures or ideologies not coming under any other foreign authorities. Thus Germany was the main partner country of Mongolia in Western Europa in first half 20s century.

Ашигласан эх сурвалж,
ном зохиолын жагсаалт

Үндэсний Төв Архив, Фонд 382. данс. З. хадгаламжийн нэгж – 51.

МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс – 1, нугалбар № 1

МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс – 3-1, нугалбар № 2.

МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс – 1-1д, нугалбар № 39, 40

МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 01ш. хадгаламжийн нэгж – 1173

МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 01. хадгаламжийн нэгж – 274.

БНМАУ-ын Гадаад харилцааны түүхчилсэн төвч лавлах, Улаанбаатар, ГЯЯ, ШУА, ГЯЯ-ны

Архив, 1987, 162-р тал

Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1921-1932), Баримтын эмхэтгэл, боть I, Улаанбаатар 2002, 560 хуудас.

Болдбаатар. Ж,

Түүх зулсан он жилүүдийн ойллого, боть I, Улаанбаатар 2003, ХБНГУ-ын

БундесАрхивт буй Монголын тухай баримт сэлт (1921-1930), 411 хуудас.

Хот суурины хувийн хэвшлийн хөгжил, хувьслын асуудалд /1921-1960/

Түүхийн ШУ-ны дэд доктор /Ph.D-/ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар

1993, 109 хуудас.

Монголын аж ахуй, эдийн засаг" (Түүхэн турван үед), боть II, Улаанбаатар 2000, 1011 хуудас.

ХХ зуучын Монголчууд, (Хатигин Г. Акимиин орчуулга), Улаанбаатар, Мон-
Судар, 2000, 248-р тал.

Mongolian Educational Venture in Western Europe / 1926-1929/, Zentralasiatische
Studien 5(1971), 247-320.

Mongol Delegation in Western Europe, /1925-1929/, Royal Central Asian Journal,
London 1944.

Идшинноров. С,

Намжим. Т,

P. A. Рупен,

Serge M. Wolff,

Serge M. Wolff,